



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/391

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Б.Ширэндэвийн нэрэмжит “Хөвсгөл судлал-2022” эрдэм шинжилгээний хурлын зардалд 7 232 500 (Долоон сая хоёр зуун мянга таван зуун) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 7 232 500 (Долоон сая хоёр зуун мянга таван зуун) төгрөгийг Засаг дарга дансны “Засаг даргын үйл ажиллаганы болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал”-аас гаргаж аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дэмжлэгээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

6711011547